



БАЯН АЙРАГ
ЭКСПЛОРЭЙШН ХХК

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026

ЗАВХАН АЙМАГ, ДӨРВӨЛЖИН СУМ

БАЯН АЙРАГ 13409А, БАРУУН БОР ТОЛГОЙ MV-017666

АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Баян Айраг Эксплорэйшн ХХК

Утас +976 77116200 5100

Факс + 976 77116100

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14240 www.bayanairag.com

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Жамъянгүний 5/3 гудамж Марко Поло
барилга 2-р давхар

Батлав.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн
газрын дарга

Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Баян Айраг Эксплорэйшн ХХК-ийн
Ерөнхий захирал

Петер Роберт Томпсон

***ЗАВХАН АЙМГИЙН ДӨРВӨЛЖИН
СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БУЙ БАЯН АЙРАГ УУРХАЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ***

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР

13409А, MV-017666 /

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2708701/

Хянасан:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн
газрын мэргэжилтэн

.....

Боловсруулсан:

Баян Айраг Эксплорэйшн ХХК-ийн
Байгаль орчны хэлтсийн дэд дарга

Б.Эрдэнэтүвшин



Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.2. ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ	4
1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ	4
1.4. ОРДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
1.5. АЛТ МӨНГӨНИЙ ХҮДРИЙГ НУРУУЛДАН УУСГАХ ТЕХНОЛОГИ	7
1.6. ТУХАЙН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
1.7. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ҮЕИЙН НЭМЭЛТ ХАЙГУУЛЫН АЖЛУУД	11
1.8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ	12
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	13
2.1. БАЙГАЛЬ ОРЧИН	13
2.2. НИЙГЭМ	14
2.3. ЭДИЙН ЗАСАГ	15
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	17
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	18
6. НӨХӨН СЭРГЭЭЛТ	21
6.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө - Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг УСЛАХ, АРЧЛАХ	21
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ	23
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ	24
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ	25
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ	26
10.1 Химийн бодисын ашиглалтын төлөвлөгөө	26
10.2 Химийн бодисын эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ	27
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	29
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	30
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	36
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	37



1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Компанийн товч танилцуулга

Манай компани 2006 оноос уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж юм. 2008 оноос Баян Айраг оноосон нэртэй 13409А ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшин, Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт, Баян Айраг нэртэй газарт уурхайн ашиглалтын үйл ажиллагаа гүйцэтгэж байна. 2013 оны 10 дугаар сараас эхлэн олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн.

1.2. Техник эдийн засгийн үндэслэл

Төслийн олборлолтын техник эдийн засгийн үндэслэлийг 2010 онд батлуулсан ба 2011, 2015, 2018, 2022 онуудад нэмэлт тодотгол хийлгэж, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан болно.

#	ТЭЗҮ	Огноо	Гүйцэтгэсэн байгууллага
1	Баян Айрагийн алт зэсийн ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл	2010	Гложекс ХХК
2	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айрагийн алт зэсийн ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол	2011	Гложекс ХХК
3	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-013409) Алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ (тодотгол)	2015	МАЙНДАТА ХХК
4	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-017666) алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол	2018	МАЙНДАТА ХХК
5	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-017666) Алт-Зэсийн ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол	2022	МАЙНДАТА ХХК

1.3. Байгаль орчны үнэлгээ

2007 онд мэргэжлийн байгууллагаар анхны байгаль орчны суурь судалгаа болон төлөв байдлын судалгаа хийлгэж, уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнөх Баян Айраг орчмын бүс нутгийн газарзүй, геологийн тогтоц, хөрсөн бүрхэвч, уур амьсгал, гидрогеологийн нөхцөл, ургамалжилт, амьтны аймаг, нийгэм эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлсон. Энэхүү суурь судалгаа болон төлөв байдлын судалгааг үндэслэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

**Байгаль Орчны үнэлгээ**

#	Ерөнхий үнэлгээ	Огноо	Гүйцэтгэгч
1	Баян Айрагийн алт зэсийн цул сульфидын орд газрыг ашиглах	2011	БОАЖЯ
2	Баян Айрагийн алт зэсийн үндсэн ордын ундны болон үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамжийн системийн шугам хоолой, 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам байгуулах	2013	БОАЖЯ
3	Баян Айраг алт зэсийн үндсэн орд олборлох ажлын хүрээнд ашиглагдах шатахуун түгээх станц болон нефтийн бүтээгдэхүүний агуулах	2013	БОНХЯ
4	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт алт, мөнгөний үндсэн ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрт химийн бодис ашиглах төсөл	2016	БОНХАЖЯ
5	Алт мөнгөний орд ашиглах төсөл /нэмэлт тодотгол/	2018	БОАЖЯ
6	Баян Айраг, Алтан хөндийн “Алт, мөнгөний исэлдсэн хүдрийн үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөл” /нэмэлт тодотгол/	2021	БОАЖЯ
7	Баян Айраг, Алтан хөндийн “Алт, мөнгөний исэлдсэн хүдрийн үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөл” /нэмэлт тодотгол/	2022	БОАЖЯ
Нарийвчилсан үнэлгээ			
1	Баян Айрагийн алт, зэсийн сульфидын орд ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	2013	Нью Ларус ХХК
2	Баян Айрагийн алт зэсийн үндсэн ордын ундны болон үйлдвэрлэлийн зориулалттай усан хангамжийн системийн шугам хоолой, 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам байгуулах	2013	Нью Ларус ХХК
3	Баян Айраг алт зэсийн үндсэн орд олборлох ажлын хүрээнд ашиглагдах шатахуун түгээх станц болон нефтийн бүтээгдэхүүний агуулахын үнэлгээ	2013	Найчрал Састайнэбл ХХК
4	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт алт, мөнгөний үндсэн ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрт химийн бодис ашиглах төсөл нэмэлт тодотгол	2016	Найчрал Састайнэбл ХХК
5	Баян Айраг (MV-013409) болон Алтан хөндийн (MV-017666) алт-мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан	2018	ЭКОС ХХК
6	Баян Айраг (MV-013409) болон Алтан хөндийн (MV-017666) алт-мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	2021	Саблайм ХХК
7	Баян Айраг болон Алтан Хөндийн алт, мөнгөний ордыг исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэр төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол /ТЭЗҮ-д нэмэлт тодотгол орсон/	2022	Саблайм ХХК
8	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2015	Эко вооч ХХК
9	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2017	Ногоон гэрэлт ирээдүй ХХК
10	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2019	Ногоон гэрэлт ирээдүй ХХК
11	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2021	Алтан шанага ХХК
12	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2023	Алтан шанага ХХК
13	Байгаль орчны төлөвлөгөөт аудитийн тайлан	2025	Алтан шанага ХХК



1.4. Ордын товч танилцуулга


Ордын нөөц АМГТХЭГ-ын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар Баян Айраг ордын нөөцийг хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ХХ-06-10 тоот дүгнэлтээр Монгол улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд дараах нөөц бүртгэгдсэн.

1. Исэлдлийн бүсийн хүдрийн нийт нөөц 5.695.625.77 тн
2. Алтны дундаж агуулга 0.92 гр/тн
3. Мөнгөний дундаж агуулга 5.71 гр/тн

Төслийн байршил Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айрагийн алт-мөнгөний үндсэн ордыг ашиглах 13409А тоот тусгай зөвшөөрлийг 2008 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн АМГТХЭГ-ын даргын тушаалаар Баян Айраг Эксплорэйшн ХХК-нд 30 жилийн хугацаатайгаар олгосон.

Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хэмжээ, га	Олгосон огноо	Аймаг,сум
Баян Айраг	13409А	6102	2008-03-24	Завхан, Дөрвөлжин
Газар зүйн солбицол : Л-46-11				
1. 94°54'08" 47°50'00"				
2. 95°02'00" 47°50'00"				
3. 95°02'00" 47°48'35"				
4. 95°04'38" 47°48'35"				
5. 95°04'38" 47°47'08"				
6. 94°54'08" 47°47'08"				



Тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Төслийн 2022 онд шинэчилсэн ТЭЗҮ-д тусгаснаар Баян Айраг ордын MV-13409А тоот тусгай зөвшөөрөлтэй лицензийн талбайн үлдэгдэл нөөцийг 2022-2024 онд олборлож дуусгахаар төлөвлөсний дагуу уулын олборлолтын ажил 2024 оны 3 дугаар сард дуусан, 2025 онд баяжуулах үйлдвэрийн буюу нуруулдан уусгах талбайд уусгалт явагдсан. 2026 онд энэхүү уусгалтын ажлыг үргэлжлүүлэн явуулна.



1.5. Алт мөнгөний хүдрийг нуруулдан уусгах технологи

Баян Айраг уурхай нь алт мөнгөний исэлдсэн хүдрийг нуруулдан уусгалтын технологиор баяжуулан ашиглаж байна. Нуруулдан уусгах талбайн ёроолын болон хажуугийн хэсэгт тусгай зориулалтын геомембраныг дэвсэн, хүдрийг нуруулдан овоолж, овоолго дээрээс дуслын системээр цианидын сулруулсан уусмалыг түгээдэг. Цианидын уусмал хүдрийн биетээр нэвчиж өнгөрөхдөө хүдэрт агуулагдах алт, мөнгийг уусгаж авдаг.

Алт, мөнгө агуулсан баян уусмалыг зориулалтын уусмалын санд хуримтлуулна. Баян уусмалыг идэвхжүүлсэн нүүрс бүхий багануудаар насос болон өөрийн урсгалын тусламжтайгаар идэвхжүүлсэн нүүрсэн дундуур дамжуулж уусмал дахь алтыг шингээж авдаг. Алтгүйжсэн ядуу уусмалыг овоолго руу буцаан түгээдэг.

Нүүрсэнд шингэсэн алтыг десорбцийн хэсэгт нүүрснээс алтыг салган хандлагдсан уусмалыг гарган электролизэд оруулж алтыг катод дээр суулгана. Катодын баяжмалд дулааны боловсруулалт хийн хайлуулж алт, мөнгөний гулдмай үйлдвэрлэж байна. Боловсруулах үйлдвэрийн ерөнхий үзүүлэлтийг дараах хүснэгтэд үзүүлээ.

Боловсруулах үйлдвэрийн ерөнхий үзүүлэлт

#	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Хүдэр уусган баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	1,100,000 тн/жил, 3041.1 тн/хоног
2	Хүдэр уусган баяжуулах үйлдвэрийн ажиллах хугацаа	1 жил 365 хоног/жил 8,322 цаг/жил
3	Уусган баяжуулах үйлдвэрийн цехийн ашиглалт	75%
4	Хүдэр бэлтгэх технологи	3 шатны бутлалт, бөөнцөглөлт
5	Бөөнцөглөсөн хүдрийн ширхэглэл	8 мм (80%)
6	Натрийн цианидийн хэрэглээ	445 - 800 тн/жил
7	Алтын металл авалт	76%
8	Мөнгөний металл авалт	48%
9	Хүдэр боловсруулах технологи	Нуруулдан уусгалт, нүүрсэнд шингээлт, десорбци электролиз

Нуруулдан уусгах талбай Энэхүү талбайд Баруун өргөтгөлийн А, В, С, 1, 2-р үүр болон 7, 8-р үүрийг 11, 12, 13-р үүр дэхь хүдрийг дахин боловсруулж уусгалт өгч нэвчилтийн ажил үргэлжлэн явагдахаар төлөвлөж байна. Мөн энэ жил бусад үүрүүдээс урсгал тогтмол хүлээн авах, шугам хэвийн ажиллана. Нуруулдан уусгалтын талбайн хүдрийн овоолгод дахин уусгалтаар нийт 722,583тн хүдэрт цианитийн уусгалт жигд өгч ажиллана.




Нуруулдан уусгах талбай, 2025 оны 10-р сарын байдлаар



Мөн нуруулдан уусгах талбайн зүүн өргөтгөлийн ажлыг 18-р үүрээс зүүн тийш 4 үүр барихаар төлөвлөн, талбайг өмнө жил газар шорооны ажил 80% -тай хийгдсэн ба цаашид хамгаалалтын далан, хамгаалалтын хулдаасан үе дэвсэлт хийх, ажлыг гүйцэтгэгч байгууллагатай гэрээгээр хийлгэхээр төлөвлөж байна. Тэлж өргөтгөж байгаа зүүн хэсгийн талбайн суваг, шуудууг ухах ажилд CAT330 эксковатор, Автосамосвал 4ширхэг, Ул талбайн тэгшилгээнд CAT D8R маркийн Бульдозер болон CAT 160K автогрейдер хэрэглэн ажиллана мөн талбайн нягтаршуулалт, хэлбэржүүлтэнд Индүү 2 ш болон усны машин 2 ш ашиглана.



Нуруулдан уусгах талбайн зүүн талын өргөтгөл, 2025 оны 10-р сарын байдлаар



Нуруулдан уусгалтын талбайн зүүн өргөтгөлийн төлөвлөлт



1.6. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2026 онд Баян Айрагийн ордын төв хэсэг болон Шохойн Хяр хэсэг, талбайн аль ч хэсэгт ашиглалт, олборлолтын уулын ажил хийгдэхгүй. Техникийн болон Биологийн нөхөн сэргээлтүүд болон уурхайн хүрээнд хөндөгдсөн газруудын нөхөн сэргээлтийн ажил бүрэн хийгдсэн ба арчилгаа, хамгаалалтын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

Нуруулдан уусгалтын хүдрийн овоолго Энд Үүр14–Үүр18 хүртэлх зөвхөн 3 болон 4 дүгээр үеийн нуруулдсан уусмалын овоолгоо баруун чиглэлд шилжүүлэн сийрэгжүүлэн, хольж шидэх ажилд 6м3 шанаганы багтаамжтай CAT-390D маркийн урвуу утгуурт гинжит экскаватор 2ш ажиллах болон бэлэн байдалт техникээр CAT-345 маркийн урвуу утгуурт гинжит экскаватор 1ш байна. Нийт 375,800м3 уусмалын овоолгыг шилжүүлэн шидэлт хийж, уусгалт өгөх талбайг бэлтгэн үргэлжлүүлэн ажиллана. Экскаватороор шидэлт хийж овоолго дахин шилжилт, хөдөлгөөн оруулж байгаа нь дараах зорилгоор хийнэ. Үүнд, овоолгоны уусгалтанд хүдрийг жигд бүрэн хамруулах, өнгөн хэсгийн нягтралтыг сийрэгжүүлсэнээр уусмалыг хүдэрт нэвчих хурдыг нэмэгдүүлэх, доод 1 ба 2 дах үеийн уусмалын нэвчилтийн хурдыг нэмэгдүүлэх, металл авалтыг нэмэгдүүлэх зэрэг юм. Нуруулдан уусгалтын овоолгын тодорхой хэсэгт агуулга хянах өрөмдлөгийн ажил хийгдэхээр төлөвлөгдөж байгаа тул тэр хэсэг талбайд Дозер/D8R/-оор тэгшилгээ хийх, зам талбай бэлтгэх техникийн ажлыг хийнэ.

Шинээр зам хийх Уурхайн төв Шимт хөрсний овоолгын талбайгаас зурагт тусгагдсан улаан сумаар заасан Кемпийн баруун талаар орон нутгийн Ташир-1 худаг руу явдаг зам руу холбосон шинэ замыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна. Энэ нь цаашид 3-р талын хүдрийг Баян-Айраг уурхайн хүдрийн овоолгын талбай хүртэл хүдэр тээвэрлэлт хийх бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх болно. Энэ онд үргэлжлүүлэн хийх замын нийт урт 1050 метр, өргөн 16 метр хэмжээст замыг хайрган хучилттайгаар хийх мөн уулархаг хэсэгт шидэлтээр түвшинг бууруулах шаардлагатай техникүүдийг ашиглана. Нийт энэ талбайгаас 3780м3 шимт болон шимэрхэг хөрсийг хуулж, шимт хөрсний овоолгод байршуулна.



Шинэ замын байршлын зураг

Хүдэр бутлан бэлтгэх, бөөнцөглөлт, нуруулдан уусгах талбайд овоолго хийх Төлөвлөгөөт засвар үйлчилгээг бутлуурын бүх тоног төхөөрөмжийн хэсэг мөн хүдэр тээвэрлэлт конвейнерийн засвар, нэмж шинээр талбайд хүдэр нуруулдахтай холбоотой төлөвлөгөөт нэмэлт тоног төхөөрөмж хийх, засварлалтын ажилууд бүрэн хийгдэнэ. Үүнд: хацарт




бутлуурын хөдлөх болон үл хөдлөх хуяг солих, конусан бутлуурын 1, 2-ийн хөдлөх болон үл хөдлөх хуяг солих, үйлчилгээ хийх, бөөнцөглөгчийн бүх дугуй шинээр солих, доторхи резенин хуяг солих, шинээр 60м урттай 4 ширхэг суурин царцаа конвейер хийх, оверланд конвейрийн 1600м туузан ремень солих, шигшүүр 1, 2-ийн холхивчууд болон тос солих, дам нуруу гагнаж засах, стакерийн гидрийн систем засах, үндсэн болон сунах конвейруудын туузан ременүүд солих, триппер конвейрийн чангалагч барбан шинээр солих, бүх суурин болон хөдөлгөөнт конвейруудын туузан ресен солих, орох гарах чутны хуяг гагнах, суурин конвейруудын хурд мэдрэгч болон удирдлагын хайрцаг шалгаж засварлах зэрэг болно.

Хүдрийн овоолгын нөөц талбайд 3-р талын хүдрийг энэ оны 6 сараас эхлэн хүдэр тээвэрлэлт хийгдэж, нөөц овоолго үүсгэнэ. Шинээр байгуулах нуруулдан уусгалтын талбайн зүүн өргөтгөлийн шинэ талбайд 3-р талын хүдрийг бутлан бөөнцөглөн, хүдэр нуруулдах бэлтгэл ажлыг 2 дугаар улиралд багтаан бүрэн ханган ажиллана.

2026 онд 3р талаас тээвэрлэгдэн ирэхээр төлөвлөж байгаа хүдрийн хэмжээ

Хугацаа	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	11 сар	12 сар	Нийт
Хүдэр /тн/	20,558	30,558	30,558	30,558	35,558	35,558	35,558	183,349
Агуулга /гр/	0.51	0.51	0.51	0.51	0.51	0.51	0.51	0.51

Уурхайн ажилчдын сууринд сайжруулалт хийх Одоогоор ашиглаж буй ажилчдын гэр кэмпд, кэмпийн зориулалтаар эзэмшиж ашиглаж буй газрын хүрээнд, хүчин чадлыг нэмэгдүүлэхгүйгээр, зөвхөн ажилчдын тав тух, аюулгүй байдал, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах зорилгоор зарим хэсгийг шинэчлэн сайжруулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын хүрээнд хийгдэх ажлууд нь шинэ газар ашиглалт, газар хөндөх, газар шорооны ажлыг нэмэгдүүлэхгүй бөгөөд инженерийн шийдлийг сайжруулах байдлаар хийгдэнэ. Үүнтэй холбогдон гарах хог хаягдлын асуудлууд дээр уурхайн Хог хаягдлын менежментийн журамын дагуу хяналттай явагдана.



Уурхайн кэмпийн засвар, сайжруулалтын ажлын ерөнхий төлөвлөлтийн зураг



1.7. Уурхайн ашиглалтын үеийн нэмэлт хайгуулын ажлууд


2026 онд Баян Айраг уурхай болон түүний эргэн тойронд нийтдээ 7,600 тууш метр 4 төрлийн зорилго бүхий баганат болон цохилтот өрөмдлөгийн ажил хийхээр төлөвлөж байна.

1. 300 (PQ) метрийг нь 128м голчтой бүдүүн диаметртай баганат өрөмдлөгөөр Зэс болон алтны хүдэржилтийн исэлдэлийн бүсийг нарийвчлоон судлах, баяжуулах үйлдвэрийн технологийн дээж авах зорилгоор өмнөх хайгуулаар илэрсэн хүдэржилт бүхий цооногтой пралеллаар 3-5 цооног өрөмдөхөөр
2. 3,000 метр (HQ) нь зэс болоод алты хүдэржилтийг гүнрүү нь дахин шалгаж нөөцийг баталгаажуулах зорилгоор өрөмдөхөөр
3. 300 (PQ) метрийг нь 128м голчтой бүдүүн диаметртай баганат өрөмдлөгөөр Баян Айргийн уурхайн гидрогеологийн нөхцөл болон уурхайн усны шүүрэл, шавхалтыг судлах зорилгоор өрөмдөхөөр тус тус төлөвлөөд байна.
4. Нуруулдан уусгалтын талбай дахь хүдрийн агуулгыг шалгахаар 4,000м RC өрөмдлөг хийхээр төлөвлөсөн, энэ өрөмдлөг металл боловсруулалтын үр дүнгээс хамааран хийгдэхгүй ч байж болно.

Дээрх бүх төрлийн өрөмдлөгт цооногийн хазайлтыг тусгай зориулалтын багажаар хэмжих ба баганат өрөмдлөг-д мөн чулуулгийн байршлыг тогтоох зорилгоор керн дээр чиглүүлэгч хийхээр төлөвлөсөн болно.

Өрөмдлөгийн ажилтай зэрэгцэн дээжлэлтийн ажил явагдах кернээс шаарлагатай гэж үзэж байгаа хэсгээс чулуулгийн хил зааг болон хүдэржилтээс хамааруулан дээжийн уртыг 1м ээс ихгүйгээр, RC цооногоос 1 метр бүрээс 1 дээж авах сонгон дээжилнэ.

Дээжийг дугаарлан, уутлаж бэлтгэсэний дараагаар ямар төрлийн шинжилгээ хийлгэхээс хамааран Улаанбаатар дахь лабораторд эсвэл уурхайд байрлах SGS-н лабораторид өгч шинжлүүлнэ.



Ашиглалтын үеийн нэмэлт хайгуулын ажлын төлөвлөгөөний зураг



1.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Баян Айраг тусгай зөвшөөрлийн талбайд 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, БОНБНУ-ний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, 2026 оны уулын ажлын төлөвлөгөөг үндэслэн боловсруулсан ба агуулга болон холбогдох зардлыг доорх хүснэгтэд нэгтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл

#	Агуулга	Зардал, мян. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	9,340.0
2	Нөхөн сэргээлт	1,340.0
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал	5,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6	Осол, эрсдлийн менежмент	2,300.0
7	Хог хаягдлын менежмент	18,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	90,355.4
9	Удирдлага зохион байгуулалт	2,000.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	1,100.0
НИЙТ ЗАРДАЛ		129,435.4



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин

Уур амьсгал Дөрвөлжин сум нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас газрын гадаргын ууршиц 118.1 мм-ээр ихэссэн, ургамлын ургалтын хугацаанд ордог хур борооны хэмжээ 33.0 мм-ээр буурсан нь хуурайшилт, цөлжилтийн гол шалтгаан болж байна. Хавар цас ханзрах хугацаа бараг нэг сараар урагшилж, хөрс цасан бүрхүүлгүй болон ургамлын бүрхэвчгүй байх хугацаа уртассан нь салхины нөлөөгөөр газрын хөрс элэгдэх нөхцлийг нэмэгдүүлж байна.

Ургамалжилт Дөрвөлжин сумын нийт газар нутгийн 68%-ийг (491346 га) бэлчээрт ашиглах боломжтой ургамал бүрхэвчтэй хэсэг, үлдсэн 32%-ийг элсэн тарамцаг, хад асга эзэлдэг ба энд нийт 210 гаруй мянган толгой мал (сүргийн 9.6% бод мал, 37% хонь, 53% ямаан сүрэг тус тус эзэлдэг) бэлчээрлэж, бэлчээрийн даац 1.5 дахин хэтэрснийг УЦУОШГ-ын бэлчээрийн даацын үнэлгээгээр тогтоосон байна. Малын тоо толгойн энэхүү өсөлт бэлчээр ашиглалтанд сөргөөр нөлөөлж, зудын болзошгүй эрсдэл, өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх, улмаар урт хугацаанд бэлчээрлэх талбай, бэлчээр дэх ургамлын төрөл зүйл, тэжээллэг чанар багасах эрсдэлийг бий болгодог.

Дөрвөлжин сум нь уур амьсгал, байгалийн бүс, бүслүүрийн онцлогоос шалтгаалаад ургамлан нөмрөг сийрэг, ургамлын ногоорол (NDVI4)-ын утга нь олон жилийн дунджаар 0.14 буюу маш бага байна. Хэдийгээр говь, цөлийн бүсэд хур тунадас элбэг тохиолдолд говийн ургамлын сэргэн ургах чадамж болон уур амьсгалын эрс тэс нөхцөлд дасан зохицох чадвар өндөр харагдаж байгаа ч судалгаагаар тус сумын ургамлын биомасс тухайн жилийн хур тунадасны хэмжээ болон малын тоо толгой, бэлчээр ашиглалтаас хамаарч ихээхэн өөрчлөгдөж байна.

Цөлжилт, газрын доройтол Дөрвөлжин сумын бэлчээр ашиглалтын индекс 2016 оны байдлаар 1.5-1.7 дахин хэтэрсэн байна. Энэ нь 2010 оноос хойш тогтвортой нэмэгдэж байгаа малын тоо толгойн өсөлттэй шууд хамааралтай. Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2010 онд хийсэн цөлжилтийн судалгаанаас харахад Дөрвөлжин сумын нийт газар нутгийн 2.5% нэн хүчтэй, 1.2% хүчтэй, 36.5% дунд, 50.8% сул эрчимтэйгээр цөлжилтөд нэрвэгдэж байна. Цөлжилтөнд нөлөөлж буй хүчин зүйлийн хувьд Онц багийн нутагт байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөө, Таван толгой багийн нутагт байгалийн болон салхины нөлөө давамгайлж байгаа бол Буурал, Цогт, Буга багийн нутагт салхи болон хүний хүчин зүйлийн хавсарсан нөлөө давамгайлж хамгийн ихээр цөлжилтөнд өртсөн байна. Дөрвөлжин сумын бэлчээрийн даац дунджаар 2 дахин хэтэрсэн, харин Буурал, Цогт багуудад 3.5-4 дахин хэтэрчээ.

Усан хангамж ба хэрэглээ Тус сум нь Хяргас нуур-Завхан голын сав газарт хамрагдах ба Багануур, Завхан голоос өөр нуур, томоохон болон жижиг гол, горхи багатай, гадаргын усны нөөцөөр хомс юм. 100 гаруй тооны гүний худаг байдаг. Олон жилийн динамикаас хүн, малын усны хэрэгцээ нийлээд жилд дунджаар 370.000тн байна. Мал аж ахуйн хэрэгцээнд олон жилийн дунджаар 170.000-402.000 тн усыг жилд хэрэглэж хүн амын усны хэрэгцээнээс 10-20 дахин их усыг мал аж ахуйд ашигласаар иржээ.

Ан амьтан ба Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) Дөрвөлжин сум нь байгаль, экосистемийн хувьд биологийн олон төрөл, зүйлийн ховор, нэн ховор амьтдын амьдрах орчин, зарим амьтдын хувьд хоргодон амьдрах нэн таатай нөхцөл бүрдсэн нутаг юм. Онц багийн нутаг Сээрийн нуруунд дэлхий дээр байгальд бүрмөсөн устаж үгүй болсон цорын



ганц зэрлэг адуу тахийг сэргээн нутагшуулж байна. Үүний зэрэгцээ Монгол улсын улаан номонд орсон Хар сүүлт зээр, Бөхөн, Янгир, Шилүүс зэрэг амьтад бий. Эдгээр амьтдын тархалт, тоо толгойд нөлөөлөгч голлох хүчин зүйлс нь нүүдэл, шилжилт хийх хязгаарлагдмал нөхцөл, идэш тэжээлийн хомсдол, ган зуд зэрэг байгалийн үзэгдэл, бэлчээр, булаг шанд, задгай усны хомсдол зэргээс гадна уул уурхай, малын тооны хэт өсөлт, хууль бус агнуур зэрэг хүний шууд болон дам нөлөө шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Дөрвөлжин сумын нутагт Олон Улсын Шувуудад Чухал Газар (IBA)-ын жагсаалтад багтсан Хар нуурын шувуудад чухал газар (MN016), Хомын талын шувуудад чухал газар (MN0817) оршдог. Энд дэлхийн хэмжээнд устах аюулд орсон Борцгор хотон, Цагаантолгойт ямаансүүл, Реликт цахлай, Усны нөмрөг бүргэд, Цагаансүүлт нөмрөг бүргэд, Ундар шумбуур, Хархираа тогоруу, Жороо тоодог зэрэг 11 зүйлийн шувуу байхаас гадна түгээмэл тархацтай буюу эрсдэлийн зэрэглэл багатай олон зүйл шувууд бүртгэгдсэн байна. Сумын нутгаар дайран урсах Завхан голд тархсан Монгол хадран загас нь элбэг тархалттай зүйл боловч бүс нутгийн улаан дансны зэрэглэл, шалгуураар Эмзэг ангилалд багтана.

Онц багийн нутаг Дөрвөлжин уул орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 2004 оноос эхлэн Тахь адуу сэргээн нутагшуулж байгаль хамгааллын нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд Тахь төдийгүй Монгол орны улаан номонд орсон, ховор амьтад болох Хар сүүлт зээр, Бөхөн, Янгир, Зэгсний гахай зэргээс гадна Монгол орны баруун бүсэд тусгаарлагдаж газарзүйн тархац нь хумигдсан Цагаан зээрийг давхар хамгаалж популяцийн мониторинг судалгааг тогтмол явуулж, эргүүл хяналт хийснээр тоо толгой нь аажмаар өсч байна.

2.2. Нийгэм

Аймгийн нийт хүн амын 4 орчим хувь буюу 2153 хүн амьдардаг. Нэг хавтгай дөрвөлжин километр 0.3 хүн ноогддог тус сум нь хүн ам цөөтэй, хэт сийрэг сумын тоонд багтана. Дөрвөлжин сумын нийт оршин суугчдын 49 хувийг эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлдэг нь улс (40), баруун бүс (46), аймгийн (48) дунджаас өндөр үзүүлэлт юм. Хэдийгээр сумын нийт ажиллах хүчний 88 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа гэх боловч суман дахь ядуурлын түвшин 40 хувиас илүү хөдөлмөр эрхэлсэн ч орлого нь эдийн засгийн үр ашиг багатай, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь хүрэлцэхгүй байгаатай холбоотой. Олон жилийн туршид тасралтгүй буурч байсан хүн амын тоо сүүлийн жилүүдэд уул уурхайгаас хамааралтайгаар өсч (механик өсөлт) байна.

Боловсрол 2016-2017 оны хичээлийн жилд Дөрвөлжин сумын 9 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д 224 сурагч хамрагдсан байна. 2017 оны 3-р сарын байдлаар тус суманд 15-аас дээш настай 1509 иргэн бүртгэлтэй байгаагаас огт боловсрол эзэмшээгүй 42 (3%), бага ангийн боловсролтой 174 (12%), дипломын болон дээд боловсролтой 187 (12%), техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой 207 (14%) иргэн тус тус байна. Бичиг үсэгт тайлагдаагүй бүлэгт хүйсийн хувьд эрэгтэйчүүд зонхилж, бүрэн дунд, дээд боловсролтой эмэгтэйчүүд тус суманд ихэнх хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүд техникийн болон мэргэжлийн боловсрол түлхүү эзэмшсэн байдал харагдаж байна. Тус суманд 50 хүүхдийн хүчин чадал бүхий нэг цэцэрлэг ажиллаж, 29 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтанд хамрагдаж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгт хамрагдалт тэр хэрээр өсч байна.



Эрүүл мэнд Дөрвөлжин сум нь нийт эмнэлгийн ажилтанд ноогдох хүн амын тоогоор улсын дундаж түвшинд байгаа, сүүлийн жилүүдэд эмнэлгийн нэг ажилтанд ногдох хүн амын тоон үзүүлэлт багасч, улмаар нэг иргэнд зарцуулах эрүүл мэндийн зардал (90000 төгрөг) өсч, сумын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг илэрхийлсэн эерэг үзүүлэлтүүд гарч байгаа хэдий ч нэг их эмчид ногдох хүний тоогоор улсын дунджаас 3.2 дахин, аймгийн дунджаас 3 дахин илүү хэвээр байна.

Дөрвөлжин суманд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх, судасны тогтолцооны өвчлөл, хорт хавдар, осол гэмтэл орж байна. Хорт хавдар, артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин өвчний болон хорт хавдрын шинэ тохиолдол 21 аймгийн дундажтай харьцуулахад өндөр байна. Хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаанд халдварт бус өвчлөл давамгайлж таргалалт, хөдөлгөөний дутагдал, архи, тамхины хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлийн тархалт их байгаатай холбоотой юм.

2.3. Эдийн засаг

Дөрвөлжин сумын эдийн засаг мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, байгалийн нөөцийн ашиглалт (чацаргана, суль, цульхир г.м.), төрийн захиргаа, үйлчилгээ, бизнес худалдаа, уул уурхай, газар тариалан зэрэг 7 төрлийн эх үүсвэрээс бүрдэж сумын эдийн засаг хангалттай сайн төрөлжиж эхэлж байгааг илэрхийлнэ. Сумын нийт өрхийн 50 гаруй хувь нь мал аж ахуйн салбараас 100 хувь хамаарч, үлдсэн 50 хувь нь хосолмол байдлаар эдийн засгийн эх үүсвэрээ бүрдүүлж байна.

Мал аж ахуй Дөрвөлжин сумын эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй ба өнөөгийн байдлаар малын тоо 210 гаруй мянган толгойд хүрч бэлчээрийн даацаас 2.2 дахин хэтэрсэн нь сумын хэмжээнд бий болж буй хөрсний элэгдэл, цөлжилт, бэлчээрийн доройтлын нэг хүчин зүйл болж байна. Сумын нэг хүнд 120 хонин толгой мал (амьжиргааны босгоос 50 толгойгоор өндөр) ногдож, аймагтаа 5 дугаар байранд эрэмбэлэгдэж байна.

Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ): 2011 оноос эхлэн Монгол улсын төсвийн тухай хуулиар Сум Хөгжүүлэх Сан (СХС)-г бий болгож нэг суманд дунджаар 250-280 сая төгрөгийг хуваарилж байсан ба тэр нь хүүгийн хамтаар одоо нэг суманд ойролцоогоор 350-400 сая төгрөг болж өссөн байна. Түүнийг бага хүүтэй эргэн төлөгдөх сан байгуулах замаар сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ЖДҮ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглаж байна. Сумын хэмжээнд улсын бүртгэлтэй 49 ААН байгаагаас тогтмол үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ ангилалд харъяалагддаг 11 ААН байна. Эдгээр ЖДҮ-ээс 8 нь зөвхөн сумандаа, хоёр нь тойргийн сумдад, нэг нь гадаадын зах зээлд борлуулалт хийж байна.



3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баян Айраг уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд байгаль орчин, биологийн хүчин зүйлүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

Хүдрийг ил аргаар олборлон, нуруулдан уусгах технологиор баяжуулах үйл ажиллагаа явуулах төсөл нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй боловч энэ үйл ажиллагааг эхнээс нь зохих журам, стандартыг баримтлан, нарийн хяналт тавьж ажилласан нөхцөлд байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, олборлолтод өртсөн талбайг нөхөн сэргээх ажлыг явуулах боломжтой үйлдвэрлэл гэж үздэг.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсныг доорх хүснэгтэд нэгтгэлээ.

Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

	Хамрах хүрээ	Дүгнэлт
1	Газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 33% нь их сөрөг нөлөөтэй, 66% нь дунд сөрөг нөлөөлөлтэй байна.
2	Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 80% нь дунд зэрэг, 20% бага сөрөг нөлөөлөлтэй байна.
3	Хөрсөнд үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нийт нөлөөллийн 20% нь их, 80% нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.
4	Усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	33% их сөрөг нөлөөтэй, 66% нь дунд зэргийн сөрөг нөлөөтэй байна.
5	Ургамлын бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нийт нөлөөллийн 2 нь эерэг, 4 нь сөрөг нөлөөлөл байна. Сөрөг нөлөөллийн 25% нь их, 75% нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.
6	Амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 3 нь сөрөг, 1 нь эерэг. Нийт нөлөөллийн 75% дунд зэрэг сөрөг нөлөөтэй, 25 хувь нь эерэг нөлөөтэй байна.
7	Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нийгэмд нөлөөлөх нөлөөллийн 75% нь эерэг, 25% нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.



4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу 2026 онд уурхайн бүхий л үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдэлийг бууруулах зэрэгт чиглэгдсэн үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу явуулж, үр дүнд хяналт тавин ажиллана, мөн мэргэжлийн байгууллагаар тогтсон хугацаанд хөндлөнгийн хяналтыг хийлгэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн ба дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 110,000 модыг тарихаар төлөвлөсөн.

2026 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлыг **129,435.4** /нэг зуун хорин есөн сая дөрвөн зуун гучин таван мянга/ төгрөг байхаар төсөвлөсөн бөгөөд үүний 50 хувийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, “Ашигт малтмалын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс” буюу Төрийн сангийн 100900013406 тоот дансанд байршуулсан.

Баян Айраг уурхайн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан барьцаа хөрөнгийн мэдээлэл

Лицензийн дугаар	Шилжүүлсэн огноо		Тухайн жилийн БОМТ-ний төсөвлөсөн зардал, мян.төг	Байршуулсан, мян.төг	Шилжүүлэн тооцсон мян.төг
13409A	1	2013.09.19	109,647	20,000	0.0
	2	2015.05.26	135,940	27,243	20,000
	3	2016.07.18	132,213	18,076	47,243
	4	2017.05.09	137,306	3,334	65,310
	5	2019.01.25	189,833	26,260	68,644
	6	2020.01.29	218,979	14,576	93,904
	7	2021.12.28	314,406	157,203	0.0
	8	2022.04.13	312,662	156,331	0.0
	9	2023.01.18	177,070	88,535	0.0
	10	2024.01.17	311,705.4	155,852.7	0.0
	11	2025.01.06	200,714.4	100,357.7	0.0
	12	2026.01.20	129,435.40	64,717.7	18,562***
Нийт				832,486.0	

*** Тайлбар, бид 2025 оны БОМТ-ний барьцаа хөрөнгө болох 100,357,7 мян. төг-ийг байршуулахдаа алдаа гаргаж 18,562,0 мян.төг-ийг илүү байршуулсан учраас энэ зөрүүг 2026 оны БОМТ-ийн барьцаа хөрөнгөнд шилжүүлэн тооцож нийтдээ 46,155,7 мян.төг байршуулсан болно. Энэ тухай БОЯамны баталгаажуулсан албан бичиг болон баримтыг хавсаргав.



5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Агаарын чанар, цаг уурын нөхцөл					
#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Эрх зүйн баримт
1	Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техник, хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх, машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбай	Хангамж, Засварын хэлтсийн төсөвт багтсан	Хуваарьт хугацаанд	БОНБНУ
2	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах		Уулын ажлын төсөвт багтсан	Дулааны улиралд тогтмол	
3	Агаарын бохирдлын хэмжилтийн үр дүнгээр стандартын хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд, давтан хэмжилт хийж баталгаажуулах ба дахин илэрвэл эх үүсвэрт үзлэг хийж тохирох арга хэмжээг авах		Төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан	Хуваарьт хугацаанд	
4	Цаг агаарын мэдээг үйл ажиллагаандаа ашиглах				
5	Завхан аймгийн Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох төлөвлөгөө хэрэгжүүлэхэд хамтран ажиллах		Ү.а- ны төсөвт багтсан	2026 онд	БОГ
2. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлий					
5	Хөрсний шинжилгээгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж бохирдсон хөрсний талбайд шилжүүлэх	Төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Тухай бүрт	БОНБНУ
6	Хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх	Түр хадгалах хогийн цэгт		Хуваарьт хугацаанд	
7	Улиастай суманд хуримтладсан хаягдал хуванцар савны хаягдлыг тээвэрлэх	УБ дах дахивар авах төвд хүргэх		2026 онд	Орон нутгийн хүсэлтээр
8	Хогийн цэгт хашаа барихад дэмжлэг үзүүлэх	Дөрвөлжин сумын нэгдсэн хогийн цэгт хашаа хамгаалалт хийх		2026 онд	
3. Ургамлын нөмрөг					
9	Шинээр газар хөндөлт хийх нөхцөлд тухайн газарт үзлэг хийж, хуулах шимт хөрсний зузааныг тогтоож, ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийг тодорхойлж, бүртгэл хийх	Газар хөндөлт хийсэн талбайн хэмжээгээр	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Газар хөндөлт хийх бүрт	БОНБНУ



4. Гадаргын ба газрын доорх усны нөөц

	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
10	Кэмгийн ЦБ-н ажиллагаанд хяналт тавьж, ахуйн бохир усыг стандартад нийцүүлэн цэвэрлэх	Уурхайн талбай	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Тогтмол	БОНБНУ	
11	Цэвэрлэх байгууламжаас үүссэн лагийг Завхан аймгийн стандарт хэмжилзүй газраар шинжлүүлж (тус лаборатори энэ шинжилгээг хийх боломжтой нөхцөлд), энгийн болон аюултай хаягдлын зэрэглэлийг тодорхойлуулах		Үйл ажиллагааны төсөвт багтсан			Жилд нэг удаа		
12	Кэмгийн цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан усыг зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд дахин ашиглаж цэвэр усны нөөцийг хэмнэх	Усны нөөц	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Дулааны улиралд		
13	Гүний усны шинжилгээний үр дүнгээр стандартын хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд, давтан хэмжилт хийж баталгаажуулах		Үйл ажиллагааны төсөвт багтсан			Шаардлагатай тохиолдолд		
14	2026 оны ус ашиглах дүгнэлтийг шинэчлэх	Уурхайн ус ашиглалттай холбоотой бүхий л асуудлууд	төг	1000.0	1	1000.0	1-р улиралд	Усны тухай хууль
15	ХНЗГСГЗ-аас 2026 онд ус ашиглуулах зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллах		-	-	-	-	1-р улиралд	Усны тухай хуулийн 28.6, 29.1
16	Ус бохирдуулсны дүгнэлт авах		-	-	-	-	Улирал бүрт	
17	2026 онд ашигласан болон бохирдуулсан усны төлбөрийг төлөх		төг	Үйл ажиллагааны төсөвт багтсан		-	Сар бүр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль
18	Ус хангамжийн хоолой, усны тоолуурын бүрэн бүтэн байдал, ажиллагаанд төрийн байгууллагуудтай хамтран байнгын хяналт тавих		төг	200.0	12	2400.0	Сар бүр	
Дэд дүн						3,400.0		



5. Хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ			Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
19	Хөрсний дээж авах	Мониторингийн хөтөлбөрийн хүрээнд	төг	2420.0	-	2420.0	4, 8 дугаар сард	Тухайн дээжийг авах заавар, стандартын дагуу
20	Агаар орчны хэмжилт хийх		төг		-			
21	Усны хяналтын цооногуудаас гүний усны дээж авах		төг		-			
22	НУТ-н гүний усны хяналтын цооногуудаас усны дээж авах		төг	2200.0	-	2200.0	Жилд 2 удаа	
23	НУТ-н хөрсний хяналтын цэгүүдээс хөрсний дээж авах		төг	1320.0	-	1320.0		
24	Завхан голоос ус болон хөрсний дээж авах, хөрс усыг бохирдуулахгүй байх		Үйл ажиллагааны төсөвт багтсан.				Жилд 2 удаа	-
Дэд дүн						5,940.0		
НИЙТ ДҮН						9,340.0		



6. НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уурхайн талбайд хаягдал чулуулгийн овоолгын бүхий л талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж дуусгасан тул 2026 онд Төв овоолгын дээд хэсэгт 11.4 га, баруун хаягдлын овоолгын 6.2 га талбайд усалгаа, арчилгааны ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны явцад нөхөн сэргээлт хийх талбай бий болвол бид төлөвлөгөөт оны сүүлийн тайланд оруулан мэдээлэх болно.

6.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө - Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг услах, арчлах

#	Зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Хугацаа ба давтамж	Эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	Баян Айраг талбайн төв хаягдал чулуулгийн овоолгод өмнө жил тарьсан олон наст ургамлын усалгаа, арчилгааг хийх	11.4 га	0.0679	890.0	5-9р сар	MNS 5918:2008
2		Баян Айраг талбайн баруун хаягдал чулуулгийн овоолгод өмнө жил тарьсан олон наст ургамлын усалгаа, арчилгааг хийх	6.2 га	0.0679	450.0	5-9р сар	
Нийт			17.6	-	1340.0		

Нөхөн сэргээлтийн усалгаа хийх талбайн координатын цэгүүд

Баян Айраг – Хаягдал чулуулгийн төв овоолго (ХЧО) 11.4 га			
Дээд налуунууд 10.2 га		Хойд налуунууд 1.3 га	
648852.3126	5297561.646	648812.32	5297823.41
648855.69	5297571.35	648819.11	5297807.52
648723.294	5297659.322	648870.82	5297783.48
648685.177	5297728.02	649054.69	5297797.14
648708.85	5297765.34	649057.31	5297806.38
648769.82	5297757.82	648916.26	5297876.49
648995.23	5297682.79	648870.16	5297871.86
648985.1965	5297649.672	648836.89	5297839.78
649081.02	5297613.08	648812.32	5297823.41
649134.7897	5297499.598		
649162.02	5297335.13		
649139.1831	5297315.872		
649109.6194	5297319.579		
648999.54	5297413.6		
648904.93	5297462.81		
648829.05	5297487.33		
648735.1268	5297602.602		



648692.4735	5297672.24		
648852.3126	5297561.646		
Баян Айраг - Баруун хаягдал чулуулгийн овоолго (ХЧО) 6.2 га			
648580.163		5297971.554	
648416.767		5297841.471	
648596.233		5297943.719	
648596.027		5297937.153	
648499.262		5297767.521	
648476.675		5297649.394	
648428.639		5297676.52	
648335.327		5297655.221	
648318.06		5297662.563	
648282.711		5297735.389	
648288.795		5297749.334	
648305.03		5297791.009	
648273.45		5297895.069	
648432.862		5297929.406	
648580.163		5297971.554	



Төв хаягдал чулуулгийн овоолго - Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд усалгаа, арчилгаа хийх ажлын төлөвлөлтийн зураг /11.4 га/



Баруун хаягдал чулуулгийн овоолго - Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд усалгаа, арчилгаа хийх ажлын төлөвлөлтийн зураг /6.2 га/



7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ

БОЯБ-ын дүйцүүлэн хамгаалах ажлыг 2024 оноос эхлэн Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод тарих хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

2025 онд БОЯБ-ын дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд,

1. Мод тарихаар заагдсан талбайд 2026 онд 110,000 модыг тарих
2. Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт 2024 онд тарьсан 340,000 мод, 2025 онд тарьсан 318,000 модны усалгаа, арчилгааг үргэлжлүүлэн хийнэ, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийнэ.
3. Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт ашиглалтын 3 дугаар худгийн хашаанд тарьсан 15,000 модны усалгаа, арчилгааг үргэлжлүүлэн хийнэ, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийнэ.
4. Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт 2024 онд тарьсан 340,000 модыг мэргэжлийн байгууллагад шалгуулан акт үйлдэн хүлээлгэж өгөх
5. Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт ашиглалтын 3 дугаар худгийн хашаанд тарьсан 15,000 модыг мэргэжлийн байгууллагад шалгуулан, акт үйлдэн хүлээлгэж өгөх
6. Дөрвөлжин сумын нутагт Байгалийн чацарганы шугуйд техник ашиглан 10 хүртэл га талбайд сийрүүлэлт, цэвэрлэгээний ажлыг хийх

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

#	Зорилт	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бичиг
1	Мод тарих	Заагдсан талбайд	110,000 ш	Ү.а төсөвт	2026 онд	Мод тарих агротехник, БОАЖ Сайд, Сангийн сайдын тушаал 2021.07.09 А/172, 116
2	Тарьсан модны усалгаа, арчилгаа хийх	Завхан аймаг, Дөрвөлжин сум, Хандын эрэгт 2024 онд тарьсан мод	340,000 ш	5,000.0	2026 онд	
3		Завхан аймаг, Дөрвөлжин сум, Хандын эрэг 2025 онд тарьсан мод	318,000 ш			
4		Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум, Ашиглалтын 3-р худаг 2024 онд тарьсан мод	15,000 ш			
5	Тарьсан модыг хүлээлгэж өгөх	Завхан аймаг, Дөрвөлжин сум, Хандын эрэгт 2024 онд тарьсан мод	340,000 ш	Үйл ажиллагааны төсөвт багтсан	2026 онд	-
6		Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум, Ашиглалтын 3-р худагт 2024 онд тарьсан мод	15,000 ш			-
7	Байгалийн ойд арчилгаа хийх	Дөрвөлжин сумын Хар бутны шугуйд сийрүүлэлт, арчилгаа хийх	10 хүртэл га талбайд			2026 онд
	Нийт дүн			5,000.0		



8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ

2013, 2022 онд уурхайн нөлөөллийн бүсэд байгаа малчдын өвөлжөөг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж, нөхөн олговоруудыг олгосон бөгөөд 2024 онд нүүлгэн шилжүүлэх ажил дууссан тул төлөвлөгөөнд тусгаагүй болно.

**9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ**

#	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /ман.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн бүсэд байгаа хадны зургууд	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөхгүй байх талаар ажилтнуудад зааварчилгаа өгөх	Төслийн талбайд байгаа бүх ажилтнууд	Тухай бүрт	-	-	Шинээр ажилд орж байгаа хүн бүрт ажил эхлэхээс өмнө нэг удаа	Соёлын өвийг хамгаалах тухай
2	Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор шинээр илрэх тохиолдолд	Орон нутаг болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад мэдэгдэж зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллах	Төслийн нийт талбай	Илрэх үед	***	***	-	
НИЙТ ДҮН						-		

*** Урьдчилан төсөвлөх боломжгүй зардлын төрөлд хамаарна.



10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Гол зорилт Химийн бодисын ашиглахдаа түүнээс үүсэх эрсдэлийг бууруулах үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ. Химийн бодисын зарцуулалтын тайланг заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад тайлагнана.

Агуулга Химийн бодисын тээвэрлэлтийг Улаанбаатар хот–Өвөрхангай аймаг–Баянхонгор аймаг–Говь-Алтай аймаг–Ховд аймгийн Ховд хот–Завхан аймгийн Дөрвөлжин сум–Баян Айраг уурхай (1850 км) маршрутын дагуу гүйцэтгэнэ, маршрут өөрчлөгдөх бол холбогдох байгууллагад мэдэгдэнэ. 2026 онд ашиглах Натрийн цианидын тээвэрлэлт бүрийн өмнө төрийн байгууллагаас зохих зөвшөөрлийг авч, аюулгүй байдлыг хангана. Тээвэрлэлтийг мэргэжлийн, эрх бүхий, аюултай ачаа тээвэрлэх туршлагатай аж ахуйн нэгжтэй хамтран хийх ба аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэн, хянуулж, баталгаажуулна.

Баян Айраг уурхайд хэрэглэх химийн бодисуудыг зориулалтын агуулахад хадгалах ба 24 цагийн харуул хамгаалалттай, компанийн дотоод журмын дагуу лацдаж цоожилсон байна.

Хүрэх үр дүн Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, зарцуулалтад тогтмол хяналт тавьж, химийн бодисын эрсдэлгүй ажиллана.

10.1 Химийн бодисын ашиглалтын төлөвлөгөө

2026 онд боловсруулах үйлдвэр болон нуруулдан уусгах талбайд дараах химийн бодисуудыг ашиглана.

#	Монгол нэршил	Гадаад нэршил	CAS	Томъёо	Төлөвлөгөө
Боловсруулах үйлдвэрт ашиглах химийн бодис					
1	Цианид натри	Sodium cyanide	143–33–9	NaCN	518.6 тн
2	Азотын хүчил	Nitric acid	7697–37–2	HNO ₃	11.24 тн
3	Давсны хүчил	Hydrogen chloride	7647–01–0	HCl	33 тн
4	Сульфамик хүчил	Sulfamic acid	5329–14–6	H ₃ NSO ₃	1.71 тн
5	Натрийн гидроксид	Caustic soda	1310–73–2	NaOH	43 тн
6	Натрийн карбонат	Sodium carbonate	497–19–8	Na ₂ CO ₃	2.29 тн
7	Натрийн тетраборат	Sodium tetraborate	1303–96–4	Na ₂ B ₄ O ₇	3.98 тн
8	Антискалант	Antiscalant	Байхгүй	байхгүй	23.16 тн
9	Идэвхжүүлсэн нүүрс	Activated carbon	7440–44–0	C	24.00 тн
10	Цемент	Cement	байхгүй	байхгүй	7704.12
11	Силикат	Silica	7631-86-9	SiO ₂	0.31 тн
12	Глицин	Glycine	56-40-6	C ₂ H ₅ NO ₂	0 тн
Боловсруулах үйлдвэрийн хяналтын лабораторид ашиглах химийн бодис					
1	Мөнгөний нитрат	Silver Nitrate	7761-88-8	AgNO ₃	150 гр
2	Родианид индикатор	Rhodanine indicator	536-17-4	C ₁₂ H ₁₂ N ₂ OS ₂	50 гр
3	Буфер уусмал pH 10	Buffer solution pH 10	7732-18-5 144-55-8 497-19-8	H ₂ O NaHCO ₃ Na ₂ CO ₃	1 л
4	Буфер уусмал pH 7	Buffer solution pH 7	7732-18-5 7778-77-0 7558-79-4	H ₂ O KH ₂ PO ₄ Na ₂ HPO ₄	1 л
5	Буфер уусмал pH 4	Buffer solution pH 4	7732-18-5 877-24-7	H ₂ O HOOC ₆ H ₄ CO OK	1 л



10.2 Химийн бодисын эрсдэлийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ

Болзошгүй аюул, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ		Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ашиглалтын үеийн болзошгүй аюул, ослыг бууруулах	1	Баяжуулах үйлдвэрийн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, мөрдөн ажиллах	Боловсруулах үйлдвэр	Үйл ажиллагааны төсөвт багтсан		2026 оны эхээр		Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2017 он 54/A/136/A/2 15
	2	Химийн бодисын зарцуулалт болон сав, баглаа боодлын бүртгэл хөтөлж хяналт тавих		Үйл ажиллагааны төсөвт багтсан		Тухай бүрт		
	3	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг тусгай эрх бүхий дахин боловсруулах үйлдвэрт өгөх		Хог хаягдлын менежмент хэсэгт тусгагдсан зардлаар		Шаардлагатай үед		
	4	Натрийн цианидын савлагааны гадна талын модон хавтанг шинжилгээнд хамруулах		6	150.0	900.0	Жилд нэг удаа	
	5	Химийн бодисын тухай сургалтыг дотооддоо явуулж Баяжуулах үйлдвэр, засвар, механикийн ажилтнууд, хангамжийн хэлтсийн ажилчид болон химийн бодистой харьцаж ажиллах хүмүүсийг хамруулах		Үйл ажиллагааны төсөвт багтсан		Жилд 1 удаа		
Хадгалалтын үеийн болзошгүй аюул, ослыг бууруулах	6	Натрийн цианидын импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг шинэчлэн батлуулж ажиллах	Химийн бодисын агуулахууд	Үйл ажиллагааны төсөвт багтсан		2026 оны эхээр		2017 он 54/A/136/A/2 15журам, MNS 6458:2014 MNS 5029:2011
	7	Химийн бодисын хадгалах агуулахыг хуулийн шаардлагад нийцүүлэн ажиллах. Тухайлбал: - Үзлэг шалгалт хийх - Агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавих - Агуулахын хяналтын зориулалттай багаж төхөөрөмжийг баталгаажуулалтанд хамруулан агуулахын стандартад нийцүүлэн ажиллах.		14	50.0	700.0	Жилийн турш	



Баян Айраг - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026

Нуруулдан уусгах талбайн болзошгүй аюул, ослыг бууруулах	8	Нуруулдан уусгах талбайн хяналт мониторинг тогтмол гүйцэтгэх. Тухайлбал: - Үерийн далангийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих - Нуруулдан уусгах талбайн уусмалын концентрацийг тогтмол хянах - Нуруулдан уусгах талбайгаас ялгарах синилийн хүчлийн тогтмол хянах - Синилийн хүчил хэмжигч багаж баталгаажуулалтанд хамруулах	Нуруулдан уусгах талбай	2	350.0	700.0	Долоо хоног бүр	2017 он 54/A/136/A/215 журам
Тээвэрлэлтийн үеийн бозошгүй аюул, ослыг бууруулах	9	Натрийн цианидын тээвэрлэлтийн үед аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон маршрут батлуулан ажиллах	Тээвэрлэлт бүрт	Үйл ажиллагааны төсөвт багтсан		Тээвэрлэлт хийх бүрт	2017 он 54/A/136/A/215 журам	
	10	Тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэлд аюултай ачааны тэмдэг, хор аюулын тэмдэглэгээг зохих журмын дагуу байрлуулах						
Тайлагнах	11	ТЕГ-ын Завхан аймаг дахь хэлтэст Химийн бодисын зарцуулалтын тайлан хүргүүлэх	Зарцуулалт болон хаягдал сав баглаа боодол	12	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Сар бүр	Химийн хорт болон Аюултай бодисын тухай хууль	
	12	Завхан аймгийн БОАЖГ-т Химийн бодисын зарцуулалтын тайлан хүргүүлэх		4	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Улирал бүр		
	13	Завхан аймгийн Дөрвөлжин сумын ЗДТГ-т Химийн бодисын зарцуулалтын хагас жил болон бүтэн жилийн тайлан хүргүүлэх		2	Үйл ажиллагааны төсөвт багтсан	7-р сард, жилийн эцэст		
	14	БОУАӨЯ-нд Химийн бодисын зарцуулалтын жилийн эцсийн тайлан хүргүүлэх		1	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Жилийн эцэст		
Нийт зардал			2,300.0					



11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээ

#	Хог хаягдлын ангилал Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ, эх үүсвэр	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүү лэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
Энгийн хог хаягдал								
1	Энгийн хог хаягдлын бүртгэл хөтлөх	Уурхайн талбай	тн	-	Үүссэн хэмжээгээр	Ү.а-ны төсөвт багтсан	Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль
2	Энгийн хог хаягдлыг дахин ашиглах, зайлуулах ажлыг үргэлжлүүлэх		тн	-				
3	Энгийн хаягдлын үйлчилгээний хураамж төлөх		төг	1500.0				
Аюултай хог хаягдал								
4	Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөх	Уурхайн талбай	-	-	Үүссэн хэмжээгээр	-	-	Хог хаягдлын хууль, ЗГ-ын 2018/116
6	Аюултай хаягдлыг эрх бүхий байгууллагад гэрээний дагуу шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх		тн	-		Үйл ажилла- гааны төсөвт багтсан	Хуулийн хугацаанд	
7	Аюултай хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг төлөх		-	Төг			-	
Бусад								
9	БОХ-ийн дотоод хяналт хийх /тос түлшний асгаралт, хог хаягдал гэх мэт/	Уурхайн талбай	-	-	-	-	Сард нэг удаа	БОНБНУ
НИЙТ ДҮН						18,000.0		

*** Эмнэлгийн хог хаягдлыг гэрээний дагуу Дөрвөлжин сумын эмнэлэгт хүргэнэ.

**12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

1. Агаар орчны мониторинг							
#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Дээж авах эх үүсвэрийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
1.1	<u>Тоосжилт</u> Нийт тоос, PM10, PM2.5	Хяналтын цэгүүдэд	Улиралд 1 удаа	3	100.0	1200.0	MNS4585:2025 Агаарын чанар, Суурин болон зөөврийн багажаар зааврын дагуу дээж авах
1.2	Тоосжилтын тархалт	Хяналтын цэгүүдэд	Сар бүр	10	15.0	1800.0	ЕРА хүлцэх хэмжээ, Зориулалтын бортого ашиглан идэвхгүй аргаар тооцох
1.3	<u>Агаар бохирдуулагч хий</u> - SO ₂ Хүхэрлэг хий - NO ₂ Азотын давхар исэл	Хяналтын цэгүүдэд	Улиралд 1 удаа	6	20.0	480.0	MNS4585:2025 Агаарын чанар, Зөөврийн багажаар зааврын дагуу хэмжих, дээж авах
1.4	<u>Агаар бохирдуулагч хий - утаа</u> - SO ₂ Хүхэрлэг хий - NO ₂ Азотын давхар исэл	Кэмп, Үйлдвэрийн уурын зуух, цахилгаан хангамжийн генератор	Жилд 2 удаа	3	200.0	1200.0	Мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэж, үр дүнг авах
1.5	Дуу шуугиан	Хяналтын цэгүүдэд	Улиралд 1 удаа	10	Үйл ажиллагааны төсөвт багтсан		MNS4585:2025 Агаарын чанар, Зөөврийн багаж ашиглан хэмжих
Дэд дүн						4,680	



2. Усан орчны мониторинг

2. Усан орчны мониторинг							
#		Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
2.1	Дээж, шинжилгээ	Химийн ерөнхий шинжилгээ	Цэвэрлэх байгууламж 2 цэг (орох, гарах)	Улиралд 1 удаа	80.0	640.0	MNS 4943:2015 Хаягдал ус, MNS 6734 2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус, MNS Хаягдал уснаас дээж авах
2.2		Химийн ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Орон нутгийн малчдын 4 худаг	Жилд 1 удаа	300.0	1200.0	MNS 0900:2018 Ундны ус эрүүл ахуй MNS ISO5667-11:2000 Гүний усны дээж
2.3			Тайхын хөндий 1 цооног	Жилд 2 удаа	300.0	600.0	MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ MNS ISO 5667-11:2000 Гүний уснаас дээж авах зөвлөмж
2.4			Хайрханы хөндийн 14 цооног	Жилд 2 удаа	300.0	9600.0	
2.5			Ашиглалтын 1, 2, 3 дугаар худаг	Жилд 2 удаа	300.0	1800.0	
2.6			Олборлолтын талбайн 1 цооног	Жилд 2 удаа	300.0	600.0	
2.7			Нуруулдан уусгах талбайн 17 цооног	Жилд 2 удаа	300.0	10200.0	
2.8			Завхан голын хяналтын 2 цэгт	Жилд 2 удаа	300.0	1200.0	Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын норм MNS ISO 5667-10:2001 Гол горхины уснаас дээж авах
2.9		Хүнд металл	Цэвэрлэх байгууламж 1 цэг	Жилд 2 удаа	300.0	600.0	MNS 4943:2015 Хаягдал ус, MNS Хаягдал уснаас дээж авах
2.10		Цианид, мөнгөн ус	Нуруулдан уусгах талбайн 17 цооног	Сард 1 удаа	150.0	30600.0	MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ MNS ISO 5667-11:2000 Гүний уснаас дээж авах зөвлөмж



Баян Айраг - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026

#		Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
2.11	Дээж, шинжилгээ	Микробиологи	Ашиглалтын 1, 2, 3 дугаар худаг	Улиралд 1 удаа	37.5	450.0	MNS 0900:2018 Ундны ус эрүүл ахуйн шаардлага MNS ISO 5667-11:2000 Гүний уснаас дээж авах
2.12			Цэвэрлэх байгууламж 1 цэг	Улиралд 2 удаа	28.0	112.0	MNS 4943:2015 Хаягдал ус, MNS 6734 2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус
2.13			Завхан голын хяналтын 2 цэгт	Жилд 2 удаа	37.5	150.0	MNS 0900:2018 Ундны ус эрүүл ахуйн шаардлага MNS ISO 5667-10:2001 Гол горхины уснаас дээж авах
2.14	Хэмжилт	Гүний усны түвшний хэлбэлзэл	Хайрханы хөндийн 8 цооног	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны төсөвт багтсан		-
2.15			Тайхын хөндийн 4 цооног				-
2.16			Ашиглалтын худгуудын хяналтын 6 цооног	Сард 2 удаа			-
2.17			Олборлолтын талбайн 1 цооног	Улиралд 1 удаа			-
Дэд дүн						57,752.0	



3. Хөрсний мониторинг						
#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, агаа аргачлал
3.1	Цианид, мөнгөн ус	Нуруулдан уусгах талбайн хяналтын 10 цэг	Сард 1 удаа	80.0	9600.0	MNS5850:2018 Хөрсний чанар, MNS 3298:1990 Хөрсний дээж авах
3.2	Хүнд металл	Уурхайн талбайн хяналтын 12 цэг	Улиралд 1 удаа	56.0	6720.0	
		Завхан гол 2 цэг	Жилд 2 удаа	56.0	224.0	
		Мод тарьсан талбайн ус авч байгаа цэгүүд	Жилд 2 удаа	Үйл ажиллагааны төсөвт багсан		MNS 3297:1991 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3310:1991 Хөрсний агрохимийн үзүүлэлт, MNS 3298:1990 Хөрсний дээж авах Геохимийн ангилал, MNS 3298:1990 Хөрсний дээж авах
3.3	Микробиологи	Уурхайн талбайн хяналтын 12 цэг	Улиралд 1 удаа	88.0	4224.0	
3.4	Агрохими	Шимт хөрсний овоолго 3 цэг	Жилд 2 удаа	132.0	792.0	
3.5	Хүчиллэг урсац	Хаягдал чулуулгийн овоолго	Жилд 2 удаа	266.34	2663.4	
Дэд дүн					24,223.4	



4. Ургамлын мониторинг							
#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
Байгалийн ургамлын мониторинг							
4.1	<u>Унаган ургамлын хяналт хийх</u> <u>Тусгаг бүрхэц, зүйлийн бүрдэл, ургацын хэмжээ тодорхойлох</u>	Уурхайн доторх байгалийн ургамлын харьцуулалтын талбай (Баян айраг, Шохойн чулуу)	6, 8 сард	2	750.0	1500.0	Хээрийн судалгааны аргачлал, Фото мониторинг, шугам-цэгийн бичиглэл
4.2		Уурхайн гаднах талбай (Хайрханы хөндий)					
4.3		Дүйцүүлэн хамгааллын хүрээнд Мод тарьсан талбай					
4.4	<u>Ховор ургамлын хяналт хийх</u> <u>Зүйлийн бүрдэл тодорхойлох</u>	Уурхайн доторх байгалийн ургамлын харьцуулалтын талбай					
4.5		Дүйцүүлэн хамгааллын хүрээнд Мод тарьсан талбай					
4.6	<u>Нөхөн сэргээсэн талбайн ургамлын хяналт хийх</u> <u>Тусгаг бүрхэц, зүйлийн бүрдэл, ургацын хэмжээ тодорхойлох</u>	Гадаад овоолгын нөхөн сэргээлт хийсэн талбай (Баян айраг, Шохойн чулуу)	6, 8 сард	2	1,100.0	2200.0	Хээрийн судалгааны аргачлал, Фото мониторинг, шугам-цэгийн бичиглэл
Модны мониторинг							
4.7	<u>Дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны мониторинг /амьдралт, өсөлт/</u>	- Дөрвөлжин сумын талбай - Ашиглалтын худгийн талбай - Уурхайн талбай	9 сард	1	Үйл ажиллагааны төсөвт багтсан		Арга зүйн дагуу
Дэд дүн						3,700.0	



5. Амьтны мониторинг

#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
5.1	Янгир ямааны ажиглалт (байршил, шилжилт хөдөлгөөн)	Уурхайн дотор болон уурхайн орчмын талбай	Сард 1 удаа	Үйл ажилагааны төсөвт багтсан.	Амьтны судалгааны арга зүй, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, БОНБНУ 2022
5.2	Шувуудын ажиглалт	Уурхайн орчмын талбайд замналын дагуу	Улиралд 1 удаа		
5.3	Хөхтөн амьтдын ажиглалт (байршилт, шилжилт хөдөлгөөн)		Улиралд 1 удаа		
5.4	Амьтны осол эндэгдлийн бүртгэл	Уурхайн дотор болон Уурхайн орчмын талбай	Сард 1 удаа		
6. Түүх соёлын өвийн мониторинг					
6.1	Хадны зургийн хяналт	Уурхайн талбай дахь хадны зургууд	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны төсөвт багтсан.	Бүртгэл хийх, баримтжуулах
ОХШХ-ийн НИЙТ ДҮН				90,355.4	



13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх урдирдлага зохион байгуулалтын ажил

#	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
БОМТ-ний хэрэгжилтийн явцын хяналт				
1	Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 3 дугаар зүйлийн 3.7.3 заалтуудын дагуу Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тайлагнах	Үйл ажиллагааны төсөвт багтсан.	Дотоод хяналтын нэгжийн ажлын төлөвлөгөөний дагуу	Уурхайн дотоод хяналтын мэргэжилтнүүд
Байгаль орчны сургалт				
2	Хог хаягдлын менежмент	2000	Нийт ажилтнууд	Байгаль орчны мэргэжилтнүүд
3	Уурхайн химийн бодисын хэрэглээ		Шинэ ажилтнуудад	
4	Байгаль орчны ерөнхий зааварчилгаа			
НИЙТ ДҮН		2,000.0		



14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

БОМТ-ний биелэлтийг оролцогч талуудад мэдээлэх, тайлагнах

#	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Тайлагнах							
1	БОУАӨЯам, Завхан аймгийн БО-ны Газар	Тухайн жилийн тайланг боловсруулан хүргүүлэх	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан	2026 оны 11-р сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Байгаль орчны дэд дарга	Байгаль орчны хэлтэс
2	Сумын Засаг дарга, БОХУ байцаагч, Байгаль хамгаалагч	Батлагдсан тайлангийн хувийг хүргүүлэх	Баян Айраг уурхайн БОМТ-ний биелэлтийн тайлан	БОУАӨЯам -аар хянагдан гарсан үед		Байгаль орчны дэд дарга	
3	Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргаа	Байгууллагын даргаар баталгаажуулсан Ус ашиглалтын тайлангийн хувийг хүргүүлэх	Ус ашиглалтын тайлан /улирал, бүтэн жил/	2026 онд улирал бүрт, 2027 оны 1 дүгээр сард багтаан		Ус ашиглалтын мэргэжилтэн	
4	БОУАӨЯам, ТЕГ-ын Завхан аймаг дахь салбар, Дөрвөлжин сум	Байгууллагын даргаар баталгаажуулсан Химийн бодисын тайлангийн хувийг хүргүүлэх	Химийн бодисын зарцуулалтын тайлан /сар, улирал, жил/	2025 онд сар, улирал бүрт, Бүтэн жилийн тайланг 2027 оны 1-р сард багтаан		Химич	
5	Аймгийн БО-ны газар, Байгаль хамгаалагч, уурхайн ажилтнуудад	Цахим хэлбэрээр илгээх	Байгаль орчны товч тайлан	Сар бүр		Байгаль орчны мэргэжилтнүүд	Байгаль орчны хэлтэс



Баян Айраг - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026

#	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Мэдээлэл хүргэх							
6	Аймаг, сумын мэргэжлийн байгууллагын 20-25 мэргэжилтэн	Уурхайд	Уурхайн 2026 оны БОМТ-ний хэрэгжилтийн явцыг танилцуулах	9 сард	1100.0	Байгаль орчны мэргэжилтнүүд	Байгаль орчны хэлтэс
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Дөрвөлжин, Эрдэнэхайрхан сумдын иргэдэд мэдээлэх	Шаардлагатай хэлбэрээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Шаардлагатай үед	-	Байгаль орчны мэргэжилтнүүд	Шаардлагатай газарт
8	Сонирхогч оролцогч талуудыг мэдээллээр хангах	Уурхайн талбайд эсвэл сумын захиргаа, багт	Байгаль орчны талаар тавьсан санал гомдол, хүсэлтийн дагуу холбогдох мэдээлэл өгөх	Тухайн хүсэлт тавьсан хугацаанд	-	Байгаль орчны ахлах мэргэжилтэн	Байгаль орчны хэлтэс
НИЙТ ДҮН					1,100.0		



БАЯН АЙРАГ
ЭКСПЛОРЭЙШН ХХК

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026

ЗАВХАН АЙМАГ, ДӨРВӨЛЖИН СУМ
БАРУУН БОР ТОЛГОЙ MV-017666 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Баян Айраг Эксплорэйшн ХХК

Утас +976 77116200 5100
Факс + 976 77116100

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14240
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Жамъянгүний 5/3 гудамж Марко Поло
барилга 2-р давхар

www.bayanairag.com
environment@bayanairag.com



Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.2. ОРДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.3. УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	6
1.4. БАРУУН БОР ТОЛГОЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД 2026 ОНД ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ӨРӨДМЛӨГ, ДЭЭЖЛЭЛТ БОЛОН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЕИЙН ХАЙГУУЛЫН АЖЛУУД	7
1.5. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ ЗАРДАЛ	9
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
2.1. БАЙГАЛЬ ОРЧИН	10
2.2 Нийгэм	11
2.3 ЭДИЙН ЗАСАГ	12
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24



1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Компанийн товч танилцуулга

Манай компани 2003 оноос уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж юм. Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг нэртэй газар ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Баян Айраг Эксплорэйшн ХХК нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баруун Бортолгой-1 нэртэй MV-017666 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас 2014 оны 11 дүгээр сарын 6-нд авсан.

2012-2013 онд гүйцэтгэсэн гүйцээх хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, АМГ-ын даргын 2014 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Алтан хөндий” алтны ордын нөөцийг Монгол улсын ашигт малтмалын нөөцийн бүртгэлд бүртгэсэн.

Техник эдийн засгийн үндэслэл

Төслийн техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг 2018 онд хийлгэж, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

	ТЭЗҮ	Огноо	Гүйцэтгэсэн байгууллага
1	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-013409) Алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ (тодотгол)	2015.05	Майндата ХХК
2	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-017666) алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол	2018.08	Майндата ХХК
3	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян Айраг (MV-013409) болон Алтан Хөндийн (MV-017666) алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил уурхайн аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотгол-2	2022.02	Майндата ХХК

Байгаль орчны үнэлгээ

2016 онд “Эко Тайкүүн” ХХК-иар Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэж, уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнөх Баян Айраг орчмын бүс нутгийн газарзүй, геологийн тогтоц, хөрсөн бүрхэвч, уур амьсгал, гидрогеологийн нөхцөл, ургамалжилт, амьтны аймаг, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлсон.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулан, нарийвчилсан үнэлгээг хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.



Байгаль Орчны үнэлгээ

№	Төслийн нэр	Огноо	Гүйцэтгэгч
Ерөнхий үнэлгээ			
1	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших алт, мөнгөний үндсэн ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрт химийн бодис ашиглах төсөл	2016.04.25	БОНХАЖЯ
2	Алт мөнгөний орд ашиглах төсөл (нэмэлт тодотгол-2)	2018.09.11	БОАЖЯ
3	Алт мөнгөний орд ашиглах төсөл (нэмэлт тодотгол-3)	2021.02.04	БОАЖЯ
Нарийвчилсан үнэлгээ			
1	Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших алт, мөнгөний үндсэн ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрт химийн бодис ашиглах төсөл (нэмэлт тодотгол)	2016	Natural Sustainable ХХК
2	Баян Айраг (MV-013409) болон Алтан хөндийн (MV-017666) алт-мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах, нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэрийн төсөл	2018	ЭКОС ХХК
3	Баян Айраг (MV-013409) болон Алтан хөндийн (MV-017666) алт-мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	2021	САБЛАЙМ ХХК
4	Баян Айраг болон Алтан хөндийн алт, мөнгөний ордын исэлдсэн хүдрийг ил аргаар ашиглах нуруулдан уусгах технологиор баяжуулах үйлдвэр” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	2022	САБЛАЙМ ХХК

1.2. Ордын товч танилцуулга

Ордын нөөц “Алтан хөндийн орд”-ын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн ХХ-04-09 тоот дүгнэлтээр Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд:

1. Исэлдлийн бүсийн хүдрийн нийт бодитой нөөц 2,359,508.86 тн
2. Алтны дундаж агуулга 1.10 гр/тн
3. Мөнгөний дундаж агуулга 13.36 гр/тн

Төслийн байршил Баруун Бортолгой-1 талбай Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Дөрвөлжин сумдын нутагт оршдог. Уг талбай Баян Айраг төслийн талбайгаас баруун хойш 13 км, Дөрвөлжин сумын төвөөс баруун хойш 34 км, Улиастай хотоос баруун зүгт 175 км, Улаанбаатар хотоос 1210 км-т байрладаг.




Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хэмжээ, га	Олгосон огноо	Аймаг, Сум
Баруун Бор Толгой-1	17666А	3910.87	2014-11-6	Завхан, Дөрвөлжин

Газарзүйн солбицол нь: L-46-10, L-46-11

№	Өргөрөг	Уртраг	#	Өргөрөг	Уртраг
1	94° 56' 19.81"	47° 52' 26.6"	7	95° 0' 19.91"	47° 51' 24"
2	94° 56' 19.81"	47° 52' 10"	8	95° 0' 19.91"	47° 50' 1.64"
3	94° 57' 27.83"	47° 52' 10"	9	94° 54' 7.8"	47° 50' 1.61"
4	94° 57' 27.83"	47° 51' 45"	10	94° 54' 7.79"	47° 48' 23"
5	94° 58' 58.4"	47° 51' 45"	11	94° 52' 29.79"	47° 48' 23"
6	94° 58' 58.4"	47° 51' 24"	12	94° 52' 29.81"	47° 51' 26.62"



1.3. Уулын ажлын төлөвлөгөө

Манай компанийн хүчин чармайлтаас үл хамааран Баруун бор толгой ашиглалтын лиценз бүхий талбайн газрыг эрх бүхий төрийн байгууллага шийдвэрлээгүйгээс тус талбайд олборлолт хийх зөвшөөрөл авах боломжгүй болсон учраас 2026 онд олборлолтын аливаа үйл ажиллагаа төлөвлөөгүй болно.



1.4. Баруун бор толгойн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 2026 онд төлөвлөж байгаа өрөмдлөг, дээжлэлт болон ашиглалтын өмнөх үеийн хайгуулын ажлууд


2026 онд Баруун Бор толгойн талбайд нийтдээ 11,270 тууш метр 4 төрлийн зорилго бүхий баганат болон цохилтот өрөмдлөгийн ажил хийхээр төлөвлөж байна.

1. 2,000 метр (PQ) 128м голчтой бүдүүн диаметртэй баганат өрөмдлөгөөр Баруун бор толгойн ордын хүдрээс баяжуулах үйлдвэрийн технологийн дээж авах зорилгоор өмнөх хайгуулаар илэрсэн хүдэржилт бүхий цооногтой пралеллаар 10-15 цооног өрөмдөхөөр
2. 2,000 метр (HQ) нь ордын болон төлөвлөсөн уурхайн хананы геотехникийн нөхцөлийг тодорхойлж үнэлэлт өгөх цооногууд
3. 5,270 метр (HQ) нь ордын хүдэржилтийг суналын дагуу урд хэсэгрүү нь, уналын дагуу баруун хэсэгрүү гүнрүү нь дахин шалгаж нөөцийг баталгаажуулахад зориулсан өрөмдлөг хийхээр төлөвлөөд байна.
4. Уурхайн олборлолт хийгдэх хэсэгт хүдрийн агуулгыг шалгахаар 2,000м RC өрөмдлөг хийхээр төлөвлөсөн, энэ өрөмдлөг нь уурхайн үйл ажиллагааны холбогдох зөвшөөрлүүдээс хамааран хийгдэхгүй ч байж болно.

Бүх төрлийн өрөмдлөгт цооногийн хазайлтыг тусгай зориулалтын багажаар хэмжих ба баганат өрөмдлөгт мөн чулуулгийн байршлыг тогтоох зорилгоор керн дээр чиглүүлэгч хийхээр төлөвлөсөн болно.

Өрөмдлөгийн ажилтай зэрэгцэн дээжлэлтийн ажил явагдах кернээс шаарлагатай гэж үзэж байгаа хэсгээс чулуулгийн хил зааг болон хүдэржилтээс хамааруулан дээжийн уртыг 1м ээс ихгүйгээр, RC цооногоос 1 метр бүрээс 1 дээж авах сонгон дээжилнэ.

Дээжийг дугаарлан, уутлаж бэлтгэсэний дараагаар ямар төрлийн шинжилгээ хийлгэхээс хамааран УБ дахь лабораторд юмуу уурхайд байрлах SGS-н лабораторид өгч шинжлүүлнэ.



Ашиглалтын үеийн нэмэлт хайгуулын төлөвлөгөөний зураг



1.5. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардал

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, БОНБНУ-ний тайлангийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт үндэслэн боловсруулсан ба холбогдох зардлыг дараах хүснэгтэд нэгтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл

№	Агуулга	Зардал, мян. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0.0
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал	0.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	0.0
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0.0
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	0.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	0.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6280.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0.0
Нийт зардал		7,280.0



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин

Уур амьсгал Дөрвөлжин сум нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас газрын гадаргын ууршиц 118.1 мм-ээр ихэссэн, ургамлын ургалтын хугацаанд ордог хур борооны хэмжээ 33.0 мм-ээр буурсан нь хуурайшилт, цөлжилтийн гол шалтгаан болж байна. Хавар цас ханзрах хугацаа бараг нэг сараар урагшилж, хөрс цасан бүрхүүлгүй болон ургамлын бүрхэвчгүй байх хугацаа уртассан нь салхины нөлөөгөөр газрын хөрс элэгдэх нөхцлийг нэмэгдүүлж байна.

Ургамалжилт Дөрвөлжин сумын нийт газар нутгийн 68%-ийг (491346 га) бэлчээрт ашиглах боломжтой ургамал бүрхэвчтэй хэсэг, үлдсэн 32%-ийг элсэн тарамцаг, хад асга эзэлдэг ба энд нийт 210 гаруй мянган толгой мал (сүргийн 9.6%-ийг бод мал, 37%-ийг хонь, 53%-ийг ямаан сүрэг тус тус эзэлдэг) бэлчээрлэж, бэлчээрийн даац 1.5 дахин хэтэрснийг УЦУОШГ-ын бэлчээрийн даацын үнэлгээгээр тогтоосон байна. Малын тоо толгойн энэхүү өсөлт бэлчээр ашиглалтанд сөргөөр нөлөөлж, зудын болзошгүй эрсдэл, өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх, улмаар урт хугацаанд бэлчээрлэх талбай, бэлчээр дэх ургамлын төрөл зүйл, тэжээллэг чанар багасах эрсдэлийг бий болгодог. Дөрвөлжин сум нь уур амьсгал, байгалийн бүс, бүслүүрийн онцлогоос шалтгаалаад ургамлан нөмрөг сийрэг, ургамлын ногоорол (NDVI4)-ын утга нь олон жилийн дунджаар 0.14 буюу маш бага байна. Хэдийгээр говь, цөлийн бүсэд хур тунадас элбэг тохиолдолд говийн ургамлын сэргэн ургах чадамж болон уур амьсгалын эрс тэс нөхцөлд дасан зохицох чадвар өндөр харагдаж байгаа ч судалгаагаар тус сумын ургамлын биомасс тухайн жилийн хур тунадасны хэмжээ болон малын тоо толгой, бэлчээр ашиглалтаас хамаарч ихээхэн өөрчлөгдөж байна.

Цөлжилт, газрын доройтол Дөрвөлжин сумын бэлчээр ашиглалтын индекс 2016 оны байдлаар 1.5-1.7 дахин хэтэрсэн байна. Энэ нь 2010 оноос хойш тогтвортой нэмэгдэж байгаа малын тоо толгойн өсөлттэй шууд хамааралтай. Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2010 онд хийсэн цөлжилтийн судалгаанаас харахад Дөрвөлжин сумын нийт газар нутгийн 2.5% нэн хүчтэй, 1.2% хүчтэй, 36.5% дунд, 50.8% сул эрчимтэйгээр цөлжилтөд нэрвэгдэж байна. Цөлжилтөнд нөлөөлж буй хүчин зүйлийн хувьд Онц багийн нутагт байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөө, Таван толгой багийн нутагт байгалийн болон салхины нөлөө давамгайлж байгаа бол Буурал, Цогт, Буга багийн нутагт салхи болон хүний хүчин зүйлийн хавсарсан нөлөө давамгайлж хамгийн ихээр цөлжилтөнд өртсөн байна. Дөрвөлжин сумын бэлчээрийн даац дунджаар 2 дахин хэтэрсэн, харин Буурал, Цогт багуудад 3.5-4.0 дахин хэтэрчээ.

Усан хангамж ба хэрэглээ Тус сум нь Хяргас нуур-Завхан голын сав газарт хамрагдах ба Багануур, Завхан голоос өөр нуур, томоохон болон жижиг гол, горхи багатай, гадаргын усны



нөөцөөр хомс юм. 100 гаруй тооны гүний худаг байдаг. Олон жилийн динамикаас хүн, малын усны хэрэгцээ нийлээд жилд дунджаар 370.000 тн байна. Дөрвөлжин сумын хүн ам олон жилийн дунджаар жилд 14.000-21.000 тн ус хэрэглэдэг бол цаашид 2021 оныг хүртэл хүн амын дундаж өсөлт одоогийн хэмжээнд байхаар тооцоход жилд дунджаар 18.000 тн ус хэрэглэхээр байна. Мал аж ахуйн хэрэгцээнд олон жилийн дунджаар 170.000-402.000 тн усыг жилд хэрэглэж хүн амын усны хэрэгцээнээс 10-20 дахин их усыг мал аж ахуйд ашигласаар иржээ.

Ан амьтан ба Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) Дөрвөлжин сум нь байгаль, экосистемийн хувьд биологийн олон төрөл, зүйлийн ховор, нэн ховор амьтдын амьдрах орчин, зарим амьтдын хувьд хоргодон амьдрах нэн таатай нөхцөл бүрдсэн нутаг юм. Онц багийн нутаг Сээрийн нуруунд дэлхий дээр байгальд бүрмөсөн устаж үгүй болсон цорын ганц зэрлэг адуу тахийг сэргээн нутагшуулж байна. Үүний зэрэгцээ Монгол улсын улаан номонд орсон хар сүүлт зээр, бөхөн, янгир, шилүүс зэрэг амьтад бий. Эдгээр амьтдын тархалт, тоо толгойд нөлөөлөгч голлох хүчин зүйлс нь нүүдэл, шилжилт хийх хязгаарлагдмал нөхцөл, идэш тэжээлийн хомсдол, ган зуд зэрэг байгалийн үзэгдэл, бэлчээр, булаг шанд, задгай усны хомсдол зэргээс гадна уул уурхай, малын тооны хэт өсөлт, хууль бус агнуур зэрэг хүний шууд болон дам нөлөө шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

2.2 Нийгэм

Аймгийн нийт хүн амын 4 орчим хувь буюу 2153 хүн амьдардаг. Нэг хавтгай дөрвөлжин километр 0.3 хүн ноогддог тус сум нь хүн ам цөөтэй, хэт сийрэг сумын тоонд багтана. Дөрвөлжин сумын нийт оршин суугчдын 49 хувийг эдийн засгийн идэвхтэй хүн ам эзэлдэг нь улс (40), баруун бүс (46), аймгийн (48) дунджаас өндөр үзүүлэлт юм. Хэдийгээр сумын нийт ажиллах хүчний 88 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Олон жилийн туршид тасралтгүй буурч байсан хүн амын тоо сүүлийн жилүүдэд уул уурхайгаас хамааралтайгаар өсч (механик өсөлт) байна.

Боловсрол 2016-2017 оны хичээлийн жилд Дөрвөлжин сумын 9 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургууль (ЕБС)- д 224 сурагч хамрагдсан байна. 2017 оны 3 дугаар сарын байдлаар тус суманд 15-аас дээш настай 1509 иргэн бүртгэлтэй байгаагаас огт боловсрол эзэмшээгүй 42 (3%), бага ангийн боловсролтой 174 (12%), дипломын болон дээд боловсролтой 187 (12%), техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой 207 (14%) иргэн тус тус байна. Бичиг үсэгт тайлагдаагүй бүлэгт хүйсийн хувьд эрэгтэйчүүд зонхилж, бүрэн дунд, дээд боловсролтой эмэгтэйчүүд тус суманд ихэнх хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүд техникийн болон мэргэжлийн боловсрол түлхүү эзэмшсэн байдал харагдаж байна. Тус суманд 50 хүүхдийн хүчин чадал бүхий нэг цэцэрлэг ажиллаж, 29 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтанд хамрагдаж байна. Түүнчлэн сүүлийн



жилүүдэд төрөлт нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгт хамрагдалт тэр хэрээр өсч байна.

Эрүүл мэнд Дөрвөлжин сум нь нийт эмнэлгийн ажилтанд ноогдох хүн амын тоогоор улсын дундаж түвшинд байгаа, сүүлийн жилүүдэд эмнэлгийн нэг ажилтанд ногдох хүн амын тоон үзүүлэлт багасч, улмаар нэг иргэнд зарцуулах эрүүл мэндийн зардал өсч, сумын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг илэрхийлсэн эерэг үзүүлэлтүүд гарч байгаа хэдий ч нэг их эмчид ногдох хүний тоогоор улсын дунджаас 3.2 дахин, аймгийн дунджаас 3 дахин илүү хэвээр байна.

Дөрвөлжин суманд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх, судасны тогтолцооны өвчлөл, хорт хавдар, осол гэмтэл орж байна. Хорт хавдар, артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин өвчний болон хорт хавдрын шинэ тохиолдол 21 аймгийн дундажтай харьцуулахад өндөр байна.

2.3 Эдийн засаг

Дөрвөлжин сумын эдийн засаг мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, байгалийн нөөцийн ашиглалт (чацаргана, суль, цульхир г.м.), төрийн захиргаа, үйлчилгээ, бизнес худалдаа, уул уурхай, газар тариалан зэрэг 7 төрлийн эх үүсвэрээс бүрдэж сумын эдийн засаг хангалттай сайн төрөлжиж эхэлж байгааг илэрхийлнэ. Сумын нийт өрхийн 50 гаруй хувь нь мал аж ахуйн салбараас 100 хувь хамаарч, үлдсэн 50 хувь нь хосолмол байдлаар эдийн засгийн эх үүсвэрээ бүрдүүлж байна.

Мал аж ахуй Дөрвөлжин сумын эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй ба өнөөгийн байдлаар малын тоо 210 гаруй мянган толгойд хүрч бэлчээрийн даацаас 2.2 дахин хэтэрсэн нь сумын хэмжээнд бий болж буй хөрсний элэгдэл, цөлжилт, бэлчээрийн доройтлын нэг хүчин зүйл болж байна. Сумын нэг хүнд 120 хонин толгой мал (амьжиргааны босгоос 50 толгойгоор өндөр) ногдож, аймагтаа 5 дугаар байранд эрэмбэлэгдэж байна.

Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ): 2011 оноос эхлэн Монгол улсын төсвийн тухай хуулиар Сум Хөгжүүлэх Сан (СХС)-г бий болгож нэг суманд дунджаар 250-280 сая төгрөгийг хуваарилж байсан ба тэр нь хүүгийн хамтаар одоо нэг суманд ойролцоогоор 350-400 сая төгрөг болж өссөн байна. Түүнийг бага хүүтэй эргэн төлөгдөх сан байгуулах замаар сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ЖДҮ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглаж байна. Сумын хэмжээнд улсын бүртгэлтэй 49 ААН байгаагаас тогтмол үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ ангилалд харъяалагддаг 11 ААН байна. Эдгээр ЖДҮ-ээс 8 нь зөвхөн сумандаа, 2 нь тойргийн сумдад, 1 нь гадаадын зах зээлд борлуулалт хийж байна.



3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний орчны хяналт шинжилгээний хэсэгт тусгагдсан хуваарийн дагуу тус хөтөлбөрийг Баруун бор толгой-1 талбайд 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа ба 2026 оны төлөвлөгөөнд хяналт мониторингийн ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

2026 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал 7,280,000.0 /долоон сая хоёр зуун наян мянга/ төгрөг байхаар төсөвлөсөн бөгөөд үүний 50 хувийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, “Ашигт малтмалын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс” буюу Төрийн сангийн 100900013406 тоот дансанд байршуулсан.

Баруун бор толгой–1 талбайн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан барьцаа хөрөнгийн мэдээлэл

Лицензийн дугаар	№	Огноо	Тухайн жилийн БОМТөлөвлөгөөний төсөвлөсөн зардал (мян.төг)	Байршуулсан хөрөнгө, мян.төг	
				Байршуулсан (мян.төг)	Шилжүүлэн тооцсон
MV-017666	1	2019.05.10	15,170	7,585	-
	2	2020.01.29	18,240	1,532	7,585
	3	2021.12.31	18,480	9,240	-
	4	2022.03.18	18,480	9,240	-
	5	2023.01.18	16,504	8,877	-
	6	2023.12.27	8,580	4,290	-
	7	2024.12.20	22,202		-
	8	2025.01.06	7,280.0	3,640	-
	9	2026.01.20	7,280.0	3,640	-
	НИЙТ			48.044	



4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа ба энэ талбайд ашиглалтын үеийн хайгуулын ажил явуулахаар төлөвлөсөн. Энэ ажлаас үүсэж болох сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авахаар төлөвлөлөө. Хөндлөнгийн хяналт, шинжилгээний ажлын Завхан аймгийн УЦУОШГазраас хийх юм.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
1. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлий				
1	Хөрсний шинжилгээгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж Баян Айраг уурхайн бохирдсон хөрсний талбайд шилжүүлэх	Төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Тухай бүрт БОНБНУ
2. Ургамлын нөмрөг				
2	Шинээр газар хөндөлт хийх нөхцөлд тухайн газарт үзлэг хийж, хуулах шимт хөрсний зузааныг тогтоож, ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийг тодорхойлж, бүртгэл хийх	Газар хөндөлт хийсэн талбайн хэмжээгээр	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Газар хөндөлт хийх бүрт БОНБНУ
3. Хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэх				
3	Хөрсний дээж авах		500.0	4, 8 дугаар сард Тухайн дээжийг авах заавар, стандартын дагуу
4	Агаар орчны хэмжилт хийх			
Нийт дүн			500.0	



5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байна. Харин ашиглалтын өмнөх үеийн хайгуулын ажлыг явуулахаар төлөвлөсөн ба ажил явагдахад үүсэх зам, талбай болон цооногийн орчимд эвдэрсэн газрын хэмжээгээр стандартын шаардлагын дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ. Үүнийг хийсний дараа аймаг, сумын орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад шалгуулан акт үйлдэн баталгаажуулах болно. Хайгуулын өрөмдлөгийн үед Баян Айраг уурхайн Байгаль орчны хэлтэс тогтмол хяналт тавин ажиллана.



6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.



7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.



8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.



9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.



10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байна. Энд зөвхөн ашиглалтын өмнөх үеийн хайгуулын ажлыг явуулахаар төлөвлөсөн ба ажил явагдахад тус талбайд түр суурин байр зэрэг барихгүй ба ажилтнууд тус талбайгаас зүүн талд 12км-т байрлах Баян Айраг уурхайн ажилтнуудын кэмп-д байрлаж ажиллах юм. Талбайд үүсэх хог хаягдал тухайлбал, ундаа усны сав болон ахуйгаас гарах бусад хаягдал зэргийг өдөр бүр уурхайд авч ирэн тохирох хогийн савуудад хаяна.

Мөн энд ажиллаж байгаа машин, техникээс тос түлшний гоожилт, асгаралт зэрэг үүссэн нөхцөлд тухай бүрт нь цэвэрлэж мөн Баян Айраг уурхайд авч ирэн Тостой хаягдал хадгалах агуулахад хаях ба эдгээрийг бүртгэл хөтлөн баталгаажуулна.

Энэ байдалд Баян Айраг уурхайн Байгаль орчны хэлтэс тогтмол хяналт тавин ажиллана.



11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
1. Хөрсний мониторинг						
1.1	Хүнд металл	ББТ-1 талбайн хяналтын 4 цэг	Жилд 2 удаа	225.0	1800.0	MNS5850:2018 Хөрсний чанар, MNS 3298:1990 Хөрсний дээж авах
1.2	Микробиологи		Жилд 2 удаа	25.0	200.0	MNS 3297:1991 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3298:1990 Хөрсний дээж авах
Дэд дүн					2000.0	
2. Усан орчны мониторинг						
2.1	Химийн ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Орон нутгийн 2 худаг - Урд Ташир - Хойд Ташир	Жилд 1 удаа /худгууд ажиллах үед/	380.0	2280.0	MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ MNS ISO 5667-11:2000 Гүний уснаас дээж авах зөвлөмж
Дэд дүн					2280.0	



3. Ургамлын мониторинг

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
3.1	<u>Унаган ургамлын хяналт</u> Тусгаг бүрхэц, зүйлийн бүрдэл, ургацын хэмжээ	ББТ-1 талбайн хяналтын цэгүүд	Жилд 2 удаа	100.0	200.0	Хээрийн судалгааны аргачлал, Фото мониторинг, шугам-цэгийн бичиглэл хийх аргачлал
3.2	<u>Ховор ургамлын хяналт</u> Зүйлийн бүрдэл			100.0	200.0	
				Дэд дүн	400.0	

4. Амьтны мониторинг

4.1	Шувуу, хөхтөн амьтдын ажиглалт	ББТ-1 талбайд тогтоосон замналын дагуу	Жилд 2 удаа	1500.0	1500.0	Амьтны судалгааны арга зүй, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, БОНБНУ 2018
Дэд дүн					1500.0	

5. Түүх соёлын өвийн мониторинг

5.1	Хадны зургийн хяналт	ББТ-1 талбай	Жилд 2 удаа	50.0	100.0	Бүртгэл хийх
Дэд дүн					100.0	
НИЙТ ДҮН					6280.0	



12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.



13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баруун бор толгой талбайд 2026 онд уурхайн олборлолт хийх газрын зөвшөөрөл гараагүй хэвээр байгаа тул энэ төрлийн аливаа үйл ажиллагаа явагдахгүй юм.